



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦЭЦЭРЛЭГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/34

Халбан

Хорогдсон малын сэг зэм устгах, ариутгал,  
халдваргүйтгэлийн ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11 дэх заалт, 59.1.20 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 6.3 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн 02 дугаар албан даалгавар, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2024 оны А/40 дүгээр тушаал, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/122 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын нийт нутаг дэвсгэрт хяналт үзлэг хийж зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг цуглуулж устгах, булшлах, ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохион байгуулж хэрэгжүүлэхийг бүх багийн Засаг дарга нар, Байгаль орчны ажилтнууд, сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтнүүд, "Баялаг үйл-Ундрах" хоршооны дарга, малын эмч (М.Баатаржав), "Таг дүүрэн сүрэг" мал эмнэлгийн Захирал (Н.Доржжүгдэр), бусад малын эмч мэргэжилтнүүд, мал эмнэлгийн техникийн ажилтан, малчдад үүрэг болгосугай.

2.Сэг зэм устгах, ариутгал халдваргүйтгэлийн ажил гүйцэтгэх ажлын зардлын төсвийг 1 дүгээр хавсралтаар, багуудад ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сумын төв, Могойн тосгоны айл өрхүүдийн хашаа хороо, мал нядалгаа хийсэн хашаа, цэг, талбай, хогийн цэг, зам дагуух газарт үзлэг хийж шаардлагатай тохиолдолд эзэн хариуцагч нарт шаардлага хүргүүлж ариутгал, халдваргүйтгэл хийж хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга, Улсын байцаагч, эмч (Н.Алтанхуяг), гэрээт малын эмч нар, Халбан, Бүрхээр багийн Засаг дарга нарт даалгасугай.

4.Сэг зэм устгал, ариутгал, халдваргүйтгэлийн ажлын дүн мэдээг долоо хоног бүрийн пүрэв гаригт өгөгдсөн маягаар, 05 дугаар сарын 15-нд эцэслэн гаргаж мал эмнэлгийн тасагт өгөхийг багийн Засаг дарга нар, гэрээт малын эмч нарт даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Бямбажав)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.АНХБАЯР